



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/386

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Перроны урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Д.Эрдэнэ-Очир	"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал
Нарийн бичгийн дарга:	П.Хатанбаатар	Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	О.Наранцэцэг	"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Аэродромын албаны дарга
	Б.Энх-Амгалан	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	Н.Жавхлан	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Д.Эрдэнэ-Очир/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /П.Хатанбаатар/-д үүрэг болгосугай.



Л.БЯМБАСҮРЭН